ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Гурвансайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2026/102/НА-СТА-ТШЗ**

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Азуре Хүлүг Аудит ХХК
Утас: 70110090
Цахим хаяг: audit@azure.mn

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .................... 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .................... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .................... 4
2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан .................... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .................... 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .................... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .................... 8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .................... 9
3.1 Төлбөрийн акт .................... 9
3.2 Албан шаардлага .................... 9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .................... 11

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.25 № 52

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГУРВАНСАЙХАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ О.ЦЭРЭНДОЛГОР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 88,681.5 мянган төгрөгөөр өссөн байна. Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 82 дугаар тогтоолоор 1976 онд ашиглалтад орсон 185,595.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хичээлийн хуучин байрыг акталж, данснаас хассан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

4826050177

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 73 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 89.4 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **366,609,058.06** | **469,297,057.08** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **284,005,703.05** | **383,228,468.12** |
| **311** | **Кассад байгаа бэлэн мөнгө** | **-** | **-** |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **284,005,703.05** | **383,228,468.12** |
| **3121** | **Төгрөг** | **284,005,703.05** | **383,228,468.12** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 283,782,954.67 | 383,228,468.12 |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | 222,748.38 | - |
| **33** | **АВЛАГА** | **98,674.63** | **222,748.38** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 98,674.63 | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 222,748.38 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **82,504,680.38** | **85,845,840.58** |
| **351** | **Түүхий эд материал** | **13,379,150.00** | **13,296,800.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 13,296,800.00 | 13,296,800.00 |
| 35130 | Эм боох материал | 82,350.00 | - |
| **354** | **Хангамжийн материал** | **69,125,530.38** | **72,549,040.58** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 503,600.00 | 225,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 65,636,984.18 | 70,236,594.58 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 872,000.00 | 1,192,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 80,000.00 | 40,500.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 928,200.00 | 454,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,104,746.20 | 400,446.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,666,039,849.14** | **3,841,176,718.11** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,666,039,849.14 | 3,841,176,718.11 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,591,201,403.82 | 3,767,318,014.95 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,992,880,173.82 | 4,276,680,173.82 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (765,589,678.66) | (878,633,588.58) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - | (800,000.04) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 353,533,504.20 | 349,598,352.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (89,274,141.09) | (116,983,559.18) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 123,018,166.10 | 152,034,625.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (47,569,029.53) | (40,607,045.61) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 70,000,000.00 | 70,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,032,648,907.20** | **4,310,473,775.19** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **133,267,750.03** | **54,255,082.10** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **133,267,750.03** | **54,255,082.10** |
| **413** | **Өглөг** | **133,267,750.03** | **54,255,082.10** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 4,755,979.49 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 37,993,251.44 | 4,673,500.00 |
| **4136** | **Бусад өглөг** | **90,518,519.10** | **49,581,582.10** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 90,518,519.00 | 49,581,582.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 0.10 | 0.10 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,899,381,157.17** | **4,256,218,693.09** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **3,899,381,157.17** | **4,256,218,693.09** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 473,662,503.98 | 757,462,503.98 |
| 51101 | Өмч: - төрийн | 473,662,503.98 | 757,462,503.98 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 3,165,827,976.06 | 3,238,865,511.98 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,974,609,263.76 | 3,165,827,976.06 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 191,218,712.30 | 73,037,535.92 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 259,890,677.13 | 259,890,677.13 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,032,648,907.20** | **4,310,473,775.19** |

## 2.2 Аудит хийсэн санхүү үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,931,211,440.00** | **2,007,918,571.40** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **117,025,540.00** | **102,669,571.40** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **117,025,540.00** | **102,669,571.40** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 16,529,017.00 | 10,373,900.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 16,529,017.00 | 10,373,900.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 96,494,401.00 | 81,957,194.50 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 4,002,122.00 | 10,338,476.90 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,814,185,900.00** | **1,905,249,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,580,641,000.00** | **1,642,991,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,580,641,000.00 | 1,642,991,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **233,544,900.00** | **262,257,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 233,544,900.00 | 262,257,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,738,338,615.65** | **1,931,721,858.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,738,338,615.65** | **1,931,721,858.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,738,038,484.16** | **1,929,874,242.32** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,063,665,299.62** | **1,152,346,766.97** |
| 210101 | Үндсэн цалин | 678,428,387.35 | 677,183,163.91 |
| 210102 | Нэмэгдэл | 342,775,149.27 | 385,660,807.87 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 42,299,455.21 |
| 210104 | Урамшуулал | 42,461,763.00 | 47,203,339.98 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **129,913,249.62** | **135,963,422.38** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 88,702,273.57 | 92,844,141.61 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,500,311.83 | 11,457,955.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,659,185.29 | 6,212,369.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,010,296.14 | 5,445,378.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,041,182.79 | 20,003,577.14 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **208,725,154.55** | **218,043,312.46** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,787,131.71 | 7,476,637.30 |
| 210302 | Түлш, халаалт | 194,040,490.00 | 194,040,490.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,897,532.84 | 16,526,185.16 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **23,979,250.00** | **34,286,363.50** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,336,650.00 | 9,902,180.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,208,100.00 | 8,783,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,163,000.00 | 7,194,057.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,271,500.00 | 8,406,826.50 |
| **2105** | **Нормативт зардал** | **107,300,564.90** | **147,483,605.20** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 251,200.00 | 530,750.00 |
| 210502 | Хоол, хүнс | 107,049,364.90 | 146,952,855.20 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,811,800.00** | **9,143,600.00** |
| 210604 | Урсгал засвар | 4,811,800.00 | 9,143,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **11,767,965.27** | **17,300,812.14** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 894,000.00 | 2,544,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,873,965.27 | 14,756,312.14 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **187,875,200.20** | **215,306,359.67** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,620,089.00 | 26,372,711.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 72,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 171,255,111.20 | 188,861,148.47 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **300,131.49** | **1,847,616.10** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **300,131.49** | **1,847,616.10** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 300,131.49 | 1,847,616.10 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **192,872,824.35** | **76,196,712.98** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,654,112.05 | 3,159,177.06 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,654,112.05 | 3,159,177.06 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(1,654,112.05)** | **(3,159,177.06)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **191,218,712.30** | **73,037,535.92** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,830,714,917.00** | **1,915,622,900.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **16,529,017.00** | **10,373,900.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 16,529,017.00 | 10,373,900.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 16,529,017.00 | 10,373,900.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 16,529,017.00 | 10,373,900.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,814,185,900.00** | **1,905,249,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,580,641,000.00 | 1,642,991,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,580,641,000.00 | 1,642,991,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 233,544,900.00 | 262,257,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 233,544,900.00 | 262,257,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,613,134,506.65** | **1,816,400,134.93** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,613,134,506.65** | **1,816,400,134.93** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,583,692,156.66** | **1,773,823,520.95** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,059,007,994.26 | 1,155,025,176.57 |
| 210101 | Үндсэн цалин | 691,216,487.23 | 709,207,565.95 |
| 210102 | Нэмэгдэл | 313,180,756.28 | 363,882,054.41 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 33,942,812.71 |
| 210104 | Урамшуулал | 54,610,750.75 | 47,992,744.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **129,913,249.62** | **137,942,317.64** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 88,702,273.57 | 93,045,140.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,500,311.83 | 11,457,955.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,659,185.29 | 6,212,370.12 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,010,296.14 | 5,445,378.75 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 20,041,182.79 | 21,781,473.12 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **228,737,468.51** | **251,997,583.90** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,787,131.71 | 7,476,637.30 |
| 210302 | Түлш, халаалт | 215,999,380.00 | 223,704,645.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8,950,956.80 | 20,816,301.60 |
| **2105** | **Нормативт зардал** | **70,733,865.00** | **91,747,825.00** |
| 210502 | Хоол, хүнс | 70,733,865.00 | 91,747,825.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,507,300.00** | **8,412,600.00** |
| 210604 | Урсгал засвар | 4,507,300.00 | 8,412,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **13,307,965.27** | **17,300,812.14** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 894,000.00 | 2,544,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 12,413,965.27 | 14,756,312.14 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **77,484,314.00** | **111,397,205.20** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 67,429,614.00 | 102,786,625.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,054,700.00 | 8,610,580.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **29,442,349.99** | **42,576,614.48** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **29,142,218.50** | **40,506,250.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,142,218.50 | 40,506,250.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **300,131.49** | **1,847,616.10** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 300,131.49 | 1,847,616.10 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **222,748.38** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 222,748.38 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **217,580,410.35** | **99,222,765.07** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **7,660,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,660,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 7,660,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,660,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(7,660,000.00)** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **209,920,410.35** | **99,222,765.07** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **74,085,292.70** | **284,005,703.05** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **284,005,703.05** | **383,228,468.12** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **473,662,503.98** | **259,890,677.13** | **2,968,278,463.76** | **3,701,831,644.87** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 6,330,800.00 | 6,330,800.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **473,662,503.98** | **259,890,677.13** | **2,974,609,263.76** | **3,708,162,444.87** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 191,218,712.30 | 191,218,712.30 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **473,662,503.98** | **259,890,677.13** | **3,165,827,976.06** | **3,899,381,157.17** |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 283,800,000.00 | - | - | 283,800,000.00 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 73,037,535.92 | 73,037,535.92 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **757,462,503.98** | **259,890,677.13** | **3,238,865,511.98** | **4,256,218,693.09** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| **Татаас, санхүүжилтийн орлого** | **2,227,772,400.00** | **1,905,249,000.00** | **322,523,400.00** |
| Улсын төсвөөс | 1,689,968,700.00 | 1,642,991,200.00 | 46,977,500.00 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 275,545,900.00 | - | 275,545,900.00 |
| Орон нутгийн төсвөөс | 262,257,800.00 | 262,257,800.00 | - |
| **Бараа, үйлчилгээний орлого** | **29,618,300.00** | **10,293,900.00** | **19,324,400.00** |
| Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого | 29,618,300.00 | 10,293,900.00 | 19,324,400.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,257,390,700.00** | **1,915,542,900.00** | **341,847,800.00** |
| **Ажиллагчидтай холбогдсон зардал** | **1,539,986,200.00** | **1,292,967,494.21** | **247,018,705.79** |
| **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,368,877,200.00** | **1,155,025,176.57** | **213,852,023.43** |
| Цалин | 840,088,700.00 | 709,207,565.45 | 130,881,134.55 |
| Цалингийн тусгай нэмэгдлүүд | 528,788,500.00 | 445,817,611.12 | 82,970,888.88 |
| **Нийгмийн хамгааллын шимтгэл** | **171,109,000.00** | **137,942,317.64** | **33,166,682.36** |
| Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл | 143,731,500.00 | 116,160,844.52 | 27,570,655.48 |
| Эрүүл мэндийн даатгалын хураамж | 27,377,500.00 | 21,781,473.12 | 5,596,026.88 |
| **Бараа ,үйлчилгээний урсгал зардал** | **529,386,800.00** | **521,282,276.24** | **8,104,523.76** |
| Тогтмол зардал | **253,823,800.00** | **251,997,583.90** | **1,826,216.10** |
| Гэрэл цахилгааны зардал | 10,115,000.00 | 7,476,637.30 | 2,638,362.70 |
| Түлш, халаалтын зардал | 223,708,800.00 | 223,704,645.00 | 4,155.00 |
| Цэвэр, бохир усны зардал | 20,000,000.00 | 20,816,301.60 | (816,301.60) |
| **Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал** | **275,563,000.00** | **269,284,692.34** | **6,278,307.66** |
| Хоол | 111,763,000.00 | 91,747,825.00 | 20,015,175.00 |
| Бусад бараа үйлчилгээний зардал | 87,545,300.00 | 102,706,625.20 | (15,161,325.20) |
| Мэдээлэл технологийн зардал | 17,212,800.00 | 17,300,812.14 | (88,012.14) |
| Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 8,776,500.00 | 8,610,580.00 | 165,920.00 |
| Урсгал засварын зардал | 8,434,000.00 | 8,412,600.00 | 21,400.00 |
| Бусад /үдийн цай/ | 41,831,400.00 | 40,506,250.00 | 1,325,150.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,847,616.10 | (1,847,616.10) |
| **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **2,257,390,700.00** | **1,816,097,386.55** | **441,293,313.45** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 283,782,954.67 | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 383,228,468.12 | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,328.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил, 100.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 5,228.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага тус тус хүргүүллээ.

### 3.1 Төлбөрийн акт

*Илрүүлэлт 1*: Аудитаар ажилчдын хоолны хөнгөлөлт 100.0 мянган төгрөгийг томилолтын зардалтай давхардуулж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-т (*Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал; 2.2.2. байрны зардал; 2.2.3. хоолны зардал*) гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон хоолны хөнгөлөлт 100.0 мянган төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банкин дахь 100080000955 тоот дансанд 2026 оны 03 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх*

### 3.2 Албан шаардлага

*Илрүүлэлт 1*: Аудитаар шатах тослох материал, хоолны ордер болон хүнсний материалын 3,955.0 мянган төгрөгийн зарлагын ажил гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), 13.6-д (*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*), 20 дугаар зүйлийн 20.2.5-т (*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*) гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах, зөрчлийг таслан зогсоох*

*Илрүүлэлт 2*: Тайлант хугацааны эцсээр Дундговь аймгийн эрүүл мэндийн газар, ПараДайз лайф ХХК-ийн 1,273.0 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах*) 16 дугаар зүйлийн 16.5.2-т (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*) гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийн үлдэгдэлд тооцоо нийлж, баталгаажуулж зөрчлийг арилган, зөрчлийг давтан гаргахгүй байх*

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 100.0 хувийг залруулагдаагүй алдаа, зөрчил эзэлж байна. Нийт 5,328.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь, 5,328.0 мянган төгрөгийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 5,328.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 14,089.2 мянган төгрөгөөр бага байгаа тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Аудитаар шатах тослох материал, хоолны ордер болон хүнсний материалын зарлагын ажил гүйлгээний анхан шатны баримтын иж бүрдэл хангалтгүй байна. | 1 | 3,955.0 | - | - | 1 | 3,955.0 | - | - | - | - |
| Аудитаар ажилчдын хоолны хөнгөлөлтийг томилолтын зардалтай давхардуулж олгосон байна. | 1 | 100.0 | 1 | 100.0 | - | - | - | - | - | - |
| Тайлант хугацааны эцсээр Дундговь аймгийн эрүүл мэндийн газар, ПараДайз лайф ХХК-ийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. | 1 | 1,273.0 | - | - | 1 | 1,273.0 | - | - | - | - |
| **Дүн** | **3** | **5,328.0** | **1** | **100.0** | **2** | **5,228.00** | **-** | **-** | **-** | **-** |